



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/355

Улаанбаатар хот

Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс
мал гаргах ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Журмын хэрэгжилтийг хангуулах тухай” А/1024 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Дүүргийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, мал амьтны гаралтай гоц халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд орж ирсэн малд хяналт тавих, малчин, мал бүхий этгээдэд хариуцлага тооцох шуурхай ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталж, 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулсугай.

2.Ажлын хэсгийн үйл ажиллагааны явц, үр дүнг дүүргийн Засаг даргад тухай бүр танилцуулж холбогдох арга хэмжээ авахыг дүүргийн менежер (Л.Цэеэрэгзэн)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н. Бямбагэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н. МАНДУУЛ

1525011101